

Хөдөлмөрийн үндэсний намын  
Төлөөлөх зөвлөлийн 2020.06.23-ны өдрийн  
хурлын 03 дугаар тогтоолын 21-р хавсралт

**Орхон аймгийн  
Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2020 оны ээлжит сонгуульд оролцох**

**Хөдөлмөрийн үндэсний намын  
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



2020 он  
Улаанбаатар хот

**АГУУЛГА**

**ОРШИЛ** .....2

**I. ХҮНЭЭ ДЭЭДЭЛСЭН НУТГИЙН ХӨГЖИЛ** .....3

**II. ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙГ ЭЗЭМШИХ**.....6

**III. БАЙГАЛЬД ОЙР МОНГОЛ ЗАГВАР** .....7

**IV. ИРГЭДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**.....9

**V. БАЯЛГАА ЗӨВ УДИРДАХ**.....13

## ОРШИЛ

Хөдөлмөрийн үндэсний намын 2020 оны Монгол Улсын аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулсан баримт бичиг болно.

Монгол оронд сүүлийн жилүүдэд үүссэн ардчиллын болон тогтолцооны гажуудлыг засч, үндэсний язгуур эрх ашиг, түүх соёл, уламжлал, эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, дэлхийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хүний хөгжил, хууль ёс, шударга ёс, нийгмийн ардчиллыг дээдэлсэн хүмүүнлэг, аз жаргалтай нийгмийг цогцлоон байгуулах зорилгоор, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны зорилтыг ханган биелүүлэх хүрээнд, нотолгоонд суурилж, судалгаанд үндэслэн энэхүү мөрийн хөтөлбөрийг боловсруулав.

Монгол Улсын 21 аймаг, тэдгээрийн сумд төлөвлөснийхээ дагуу хөгжиж, дэлхийн хөгжилтэй мөр зэрэгцэн алхъя гэвэл дотоодын жижиг зах зээлд хоорондоо хэт өрсөлдөж, хүч нөөцөө барах бус, олон улсын зах зээлд өрсөлдөх зарчмыг баримтлах нь чухал тул тулгарч буй асуудлаа эрэмбэлж, орон нутгийн хөгжлийн стратеги боловсруулах шаардлагатай.

Хөгжлийн стратеги нь нэн тэргүүнд аймаг, сумын иргэн хүний төлөө хүний хөгжлийг эн тэргүүнд тавьж, бусад салбаруудыг хөтлөх, хөгжлийн салхийг чиглүүлэх юм. Монгол Улсын орчин, нөхцөл байдал, дэлхийн хөгжлийн чиг хандлагыг харгалзан үзвэл дараах 3 чиглэл онц ач холбогдолтой бөгөөд эдийн засаг, нийгмийг хөгжлийн замд нь түргэн гаргахад түлхэц болно гэж бид үзэж байна. Үүнд:

- (1) **Хүний хөгжил.** Боловсрол, эрүүл мэнд, хүний хөгжилд тууштай, бодитой хөрөнгө оруулах. Нэгд, энэ асуудал өнөөдрийн Монгол улсад, аймаг орон нутагт нэн тулгамдсан, хойш тавих боломжгүй асуудал, хоёрт, дунд болон урт хугацаанд олон том асуудлын шийдэл нь хүний хөгжил юм.
- (2) **Технологийн хэрэглээ.** Блокчэйн, хиймэл оюун ухаан, аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын технологийн шийдлүүд, нанотехнологи, биотехнологи, хөдөө аж ахуй, эрчим хүч, химийн болон бусад салбарт технологийн дэвшлийг төр, бизнесийн бүх түвшний хэрэглээнд хурдтай бөгөөд бусдаас өрсөн шийдэмгий нэвтрүүлэн, өрсөлдөөний давуу талыг олж, үр шимийг нь түрүүлж хүртэнэ.
- (3) **Байгальд ойр Монгол.** Байгаль дэлхийтэйгээ шүтэн барилдсан уламжлалт монгол сэтгэлгээ, нүүдлийн соёл, амьдралын амар тайван хэв маягийг технологийн шийдэлтэй хослуулан хотын гэр хорооллыг хөгжүүлж, дэлхий дахинд ялгарах шинэ Монгол дүр төрх бүрдүүлнэ.

Аймгийн иргэдэд хурд, хүч, ялгарлыг өгөх дээрх гурван тулгуурт үндэслэн нэн тэргүүнд хэрэгжүүлэх ёстой бодлогын арга хэмжээг дараах 5 бүлэгт ангилан оруулав. Үүнд:

- 1. **Хүнээ дээдэлсэн нутгийн хөгжил** –*Хот, орон нутгийн хөгжлийн ялгааг арилгана.*
- 2. **Дэвшилтэт технологийг эзэмших** - *Шилдэг шинэ технологийг нэвтрүүлж орчин үетэй хөл нийлүүлж хөгжинө.*
- 3. **Байгальд ойр Монгол загвар** - *Унаган байгаль ба түргэн хөгжлийг хослуулж, хүн амын эрүүл ахуйн баталгааг тогтвортой хангана.*
- 4. **Иргэдэд хүртээмжтэй төрийн үйлчилгээ** – *Төрийн үйлчилгээг иргэн тус бүрд тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэнэ.*
- 5. **Баялгаа зөв удирдах** - *Эдийн засгийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулна.*



## I. ХҮНЭЭ ДЭЭДЭЛСЭН НУТГИЙН ХӨГЖИЛ

### *Хот, орон нутгийн хөгжлийн ялгааг бууруулна*

#### **Аймаг, орон нутгийн хөгжил**

- Хүн ам цөөнтэй, эх газрын эрс тэс уур амьсгалтай, экологийн эмзэг орчин бүхий уул, тал хээр, говь цөл хосолсон өргөн уудам нутагтай Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлж, засаг захиргааны олон жижиг нэгжийг томсгон, сум дундын болон аймгийн, бүсийн төвүүд зэрэг хот суурин газрыг хөгжүүлснээр хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгах бодлого баримтална.
- Орон нутгийн өөрийн удирдлагын эрхийг нэмэгдүүлж, малын хөлийн татвар зэрэг татварыг хөдөө орон нутгийн хөгжилд зарцуулах эрхийг тухайн орон нутагт нь олгох, тухайн бүсийн байгалийн баялгийн нөөцийг ашигласны эцсийн үр өгөөжийг ахиу хүртээх, байгаль орчныг хамгаалах нийтлэг асуудлыг аймаг, сум, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хамтын хүчээр шийдвэрлэж экологийн тэнцвэртэй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Малчид, мал аж ахуйн хөдөлмөр эрхлэгчдийн ахуй соёл, нийгмийн хангамжийг шинэ шатанд гаргах бодлого баримтална.
- Орон нутгийн зарим ахлах сургуулийн хөтөлбөрт малчин бэлдэх чиглэлээр хэсэгчлэн төрөлжүүлнэ.
- Сургуулийн өмнөх, суурь, бүрэн дунд, ахлах сургуулийг төрөлжүүлж, мэргэшсэн бэлдэх сургалтыг нэвтрүүлнэ.
- Сайн сургуулийн жишгийг нэвтрүүлж, багшлах боловсон хүчнийг хангамжийг сайжруулна.

#### **Аймгийн төв, суурин газарт эрүүл, тохилог орчныг бүрдүүлж хөгжүүлнэ**

- Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлэх зорилгоор арга хэмжээ авна.
- Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна.
- Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 25 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулж, агаар орчны бохирдлыг бууруулна.
- Шинэ суурьшлын бүс, дагуул хотыг хөгжүүлэхдээ төрийн өмчөөр зөвхөн төлөвлөлт хийж, дэд бүтцийг шийдвэрлэх ба барилгажилтын талбайг нээлттэйгээр дуудлага худалдаанд хамруулан хөрөнгө оруулалт босгох замаар орон сууцны хорооллыг өргөтгөнө.
- Орон сууцны хороолол, гэр хорооллын дунд ногоон байгууламж, соёл, спортын төвүүдийг байгуулах талаар хүн амын тоо, нягтаршилтаас хамааруулан хүртээмжтэй байх стандарт батлуулж, мөрдүүлнэ.

- Иргэд, хүүхдүүдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, нийтийн үйлчилгээний газар, орон сууцны нийтийн эзэмшлийн талбай зэрэгт эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын стандартыг чанд мөрдүүлнэ.
- Спорт цогцолбор, биеийн тамирын заал, талбай, цэцэрлэгт хүрээлэн, дугуй болон дугуйн төрөлт тээврийн замыг 1000 хүн тутамд нэг байхаар байгуулах зорилт тавьж, энэхүү зорилтод хүрэх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлнэ.
- Аймаг, сумдын хүүхэд залуучууд, ахмад настнуудад зориулсан сургалт, соёл, хөгжлийн төвүүдийг дэмжих арга хэмжээ авна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг хангах чиглэлээр олон улс болон Монгол Улсын хууль, журмыг баримталж, нийтийн тээвэр, үйлчилгээний газар, сургууль цэцэрлэг, барилга байгууламж зэрэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан норм дүрмийг ягштал мөрдүүлнэ.
- Төрийн байгууллагуудын барилгуудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 100 хувь хүртээмжтэй болгоно.

### Цэмцгэр гэр хороолол

- Аймаг, сумын төвийн гэр хороолол хөрөнгө оруулалтын гадна үлдэж хоцордог шударга бус байдлыг эцэслэж, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах суурь хэрэгцээг бүрдүүлэхэд хөрөнгө хуваарилалтыг чиглүүлэх бодлого баримтална.
- Агаар ба хөрсний бохирдлыг бүрэн шийдвэрлэх зорилгоор гэр хорооллыг хувийн сууц, нийтийн орон сууц хосолсон тохилог хороолол болгох хөтөлбөр хэрэгжүүлж эхэлнэ.
- Гэр хорооллын иргэд хашаандаа цэвэр бохирын төвлөрсөн болон бие даасан шийдэл бүхий дулаан сууц барихад ипотекийн зээл олгох ажлыг өргөн цар хүрээтэйгээр хэрэгжүүлнэ. Ипотекийн зээлийн хүү нь орон сууцны хорооллын зээлийн хүүгээс ихгүй байхаар зохицуулах ба үүнд олон улсын банк, санхүүгийн байгууллагын хөнгөлөлттэй эх үүсвэрийг түлхүү ашиглана.
- Гэр хорооллын иргэд хоршоо байгуулж, өөрсдийн эзэмшлийн газартаа хэсэгчилсэн дэд бүтцийн шийдэлтэй орон сууцны хороолол байгуулж, зарим хэсгийг борлуулан ашиг олох төслүүдийг хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих бодлого баримтална.

### Орон сууцны хороолол

- Нийтийн орон сууцны хуучирсан барилгуудын гаднах фасадыг шинэчилж, стандартад нийцүүлэн дулаалж, сантехникийн шугам сүлжээг шинэчлэх замаар орон сууцны насжилтыг уртасгах ажлыг Зүүн Европын улсуудын жишгээр төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор зохион байгуулах бодлого баримтална.
- Орон сууцанд дулааны тоолуур тавих замаар өртөг зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- Залуу гэр бүлийн орлогод нийцсэн орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх бодлого баримтална.



### Цэцэрлэг, сургуулийн сургалтын орчныг сайжруулна

- Цэцэрлэг, сургуулийн эргэн тойрны газар ашиглалтын байдалд аудитын дүгнэлт хийлгэж, төрөөс хүүхдэд таатай гадаад орчин бүрдүүлэхэд анхаарна.
- Орон нутгийн цэцэрлэг, сургуулийн ашиглалтыг сайжруулна.
- Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдүүдийг бүрэн хамруулах зорилгод хүрэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхэлнэ.
- Цэцэрлэг, сургуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сурах, ашиглах бүрэн боломжтой байх стандартыг нэвтрүүлж хэвшүүлнэ.



## II. ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙГ ЭЗЭМШИХ

### *Шилдэг шинэ технологийг нэвтрүүлж орчин үетэй хөл нийлүүлж хөгжинө*

- Монголын уламжлалт нүүдлийн ахуйд цахим технологи, эрчим хүчний эх үүсвэр, цэвэр усан хангамж, түүхий эд боловсруулах бичил үйлдвэрлэл мэт орчин үеийн технологийн ололтыг нэвтрүүлэх, малчдын эрүүл, тохитой орчинд амьдрах, хөгжих, аж ахуй эрхлэх боломжийг сайжруулах, энэ чиглэлд оруулсан хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
- Бэлчээрийн мал аж ахуйн гаралтай түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар нэр хүндийг өргөх санал санаачлагуудыг (тухайлбал, Хариуцлагатай нүүдэлчид) дэмжиж, малын гаралтай түүхий эдийн цахим мөшгөх системийг хэрэгжүүлэхийг дэмжих бодлого баримтална.
- Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлнэ. Хот суурин, орон нутгийн бүх түвшинд интернэт, компьютер, технологийн хэрэглээг түлхүү ашиглах, интернэт орчин хямд, хурдтай байлгах, мэдээллийн технологи хөгжих суурь нөхцөлийг бүрдүүлнэ.
- Эрчим хүчний олон төрлийн эх үүсвэрийг ашиглах, бага, дунд оврын үүсгүүрийн технологи хөгжүүлэх, нэвтрүүлэхийг дэмжих бодлого баримтална.
- Мэдээллийн технологийн чиглэлээр ажиллаж буй дотоодын компаниуд, мэргэжлийн холбоодыг дэмжиж чадавхжуулах бодлого баримтална.
- Эмнэлгийн оношилгоонд хиймэл оюун ухаан, инноваци технологийг нэвтрүүлж, явуулын оношилгооны лаборатори болон эмнэлгийг орон нутагт бүрэн нэвтрүүлнэ.
- Технологийн боловсрол, тэр дундаа мэдээллийн технологийн боловсролыг бага наснаас эхлэн бүх шатны сургалтын агуулгад системтэйгээр түлхүү оруулна
- Технологийн боловсрол олгох зориулалттай лаборатори болон бусад сурах орчныг орчин үеийн шийдлийг ашиглан сургалтын байгууллагуудад эрчимтэй нэвтрүүлнэ.
- Онлайн сургалт. Хөгжлийн хандлагыг даган танхимын бус, зөвхөн хүүхэд залуус биш бүх насны хүмүүст зориулсан онлайн, эчнээ сургалтуудыг нэвтрүүлэх, хүн өөрийгөө хөгжүүлэх боломжийг технологид суурилан олноор бий болгоно.



### III. БАЙГАЛЬД ОЙР МОНГОЛ ЗАГВАР

*Унаган байгаль ба түргэн хөгжлийг хослуулж, хүн амын эрүүл ахуйн баталгааг тогтвортой хангана*

- Уламжлалт эко соёл. Уламжлалт нүүдлийн мал аж ахуй болон малчин Монголчууд байгаль орчинтойгоо ойр амьдарч ирсэн тул өнөөгийн дэлхийн байгаль орчны бохирдол, хотжилтоос зайлсхийсэн ирээдүйг харсан загварыг хөгжүүлэх, бүх салбаруудад байгаль орчинд ээлтэй соёлыг нэвтрүүлэх, бизнесийн боломж болгоно.
- Байгаль орчны сүйрлийн эсрэг манлайлагч улс. Дэлхийн дулаарал, хүлэмжийн хийг бууруулах технологи, ногоон санхүү, бизнесийн систем хөгжүүлэн, ногоон бизнесийн мэдлэг, санхүүгийн олон улсын төв болох бүрэн боломжтой бөгөөд уламжлалт өгөгдөлтэй улс. Энэ үйлдэл, тууштай бодлогоороо дэлхийн олон нийтэд танигдан имижээ бүрдүүлж, бусад улсуудыг манлайлж, ЭЗ-ийн өсөлтийн нэг тэргүүлэх чиглэл болгоно.

#### **Байгалийн нөөцийн болон бэлчээрийн менежмент**

- Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.
- Монгол орны 70 гаруй хувийг хамардаг бэлчээрийн өөрийнх нь сэргэх чадавх болон малчдын хамтын оролцоонд тулгуурлан нутгийн тогтвортой ашиглалтыг хангах хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх бодлого баримтална.
- Монгол орны бэлчээрийн талхлагдал, доройтол цаашид газар авахаас сэргийлэх, мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг хангахад тулгуур ач холбогдол бүхий “Бэлчээрийн тухай хууль”-ийг батлан хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- Монгол орны үл олборлогдох нөөц төдийгүй хөдөөгийн хөгжил, үндэсний соёлын өв болсон бэлчээр нутгаа хадгалан хамгаалах “Бэлчээр ашиглалтын тухай хууль”-ийг батлан хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- Цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 25 хувьд, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.5 хувьд хүргэнэ.
- Дахин сэргээгдэх ан агнуурын нөөцийн менежментийг хөгжүүлж, орон нутгийн хөгжлийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ. Байгалийн нөөцийн тогтвортой менежментийн эдийн засгийн үндсийг бүрдүүлж, орлогыг шударга хуваалцах, ил тод байх зарчмыг нэвтрүүлнэ.
- Хог хаягдлыг бууруулах, ангилан хаях, дахин ашиглах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хог хаягдлыг цуглуулах тогтолцоог ядуурлыг бууруулахтай уялдуулан хэрэгжүүлнэ.
- Усны бохирдлыг бууруулна. Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, хур тунадас, гадаргын ус хуримтлуулах 2-оос доошгүй улсын хэмжээний томоохон усан сан байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 15 хувьд хийх зорилгоор арга хэмжээнүүдийг авч эхэлнэ.
- Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Official red stamp and signature of the Ministry of Natural Resources and Environmental Conservation of Mongolia.



- Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 85 хувьд хүргэж, хүн амын 50 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжийг барих зорилгоор арга хэмжээг авч эхлүүлнэ.
- Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгохыг бодлогоор дэмжиж, аймгийн төв, хот, суурин газрыг дахин төлөвлөх, барилгын дулааны алдагдлыг 20 хувиар бууруулна.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги боловсруулж хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхыг бэхжүүлж, байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох, иргэдийн дасан зохицох болон гамшгаас хамгаалах мэдлэгийг насан туршийн боловсролын тогтолцоогоор олгоно.
- Ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт малчин айлд очих, тодорхой хугацаанд ажиллаж, ахуй соёлоос суралцах байгаль орчноо хамгаалах агуулгыг нэвтрүүлнэ.
- Байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог 5 дахин нэмэгдүүлэх.
- Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжиж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах бодлого баримтална.
- Хүлэмжийн хий бууруулах, байгаль хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилга, ногоон төсөл хөтөлбөрүүдийг дэмжих, санхүүжилт, хөрөнгө оруулалт татах зориулалттай төр хувийн хэвшил хамтарсан санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх бодлого баримтална.
- Хувийн хэвшлийн оролцоо, хариуцлага, хөрөнгө оруулалтыг түлхүү татан оруулах, ногоон зээл санхүү, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогын орчин бий болгоно.



#### IV. ИРГЭДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


*Төрийн үйлчилгээг иргэн тус бүрд тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэнэ*

##### **Сайн боловсрол хөгжлийн үндэс**

- Улсын үндэс нь болсон иргэнээ дээдэлж, гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, ахмадаа хүндэлдэг, хүүхэд балчраа хайрладаг, өндөр ёс суртахуунтай, журам жудагтай монгол иргэнийг хөгжүүлэхийг эрхэмлэнэ.
- Хууль журмыг ягштал биелүүлдэг, бусдыг хүндэтгэдэг, цаг баримталдаг, үнэний төлөө, зөвийн төлөө, шударгын төлөө тууштай тэмцэх ёс зүйн хүмүүжлийг бага наснаас нь суулгах, нийгмийг гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна.
- Эрх чөлөө, ардчиллын үнэт зүйлийг хүлээн зөвшөөрч, иргэний эрх, үүргээ ухамсарлан биелүүлдэг, ёс зүйтэй, хариуцлагатай, үндэсний бахархал, эв нэгдлийг эрхэмлэдэг иргэдийг төлөвшүүлнэ.
- Сургуулийн өмнөх боловсролыг “хүүхдийг сургах, сургуульд бэлтгэх” гэсэн зорилгоос илүүтэйгээр хүн болон төлөвших үндэс, өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих, насан туршийн боловсролын суурь үе хэмээн хөгжүүлнэ.
- Шавь төвтэй, бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх сургалтын арга барилыг бэхжүүлнэ.
- Бага сургуулийн сургалтыг хэт академик байдлаас ангижруулж, чадварт суурилсан, хүүхэд бүрийг ахицаар нь үнэлдэг тогтолцоонд шилжүүлнэ.
- Бүрэн дунд боловсролыг мэргэжлийн сургалттай хослуулсан аж үйлдвэр болон хөдөө аж ахуйн гүнзгийрүүлсэн сургалтыг төрөөс дэмжинэ.
- Аймгийн хэмжээнд “Хос хэлтэн” болох зорилт тавьж, зохих бэлтгэл ажлыг хэрэгжүүлнэ. Гадаад хэлний мэдлэгийг түлхүү анхаарч, танхимын болон онлайн сургалтыг эрчимтэй нэвтрүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлээс үл хамаарсан тэгш хамруулан сургалтыг ерөнхий боловсролд бүрэн нэвтрүүлэхийг дэмжинэ.
- Сурагчдын насны онцлогт тохирсон эрүүл мэндийн мэдлэг болон дадал хэвшлийг системтэйгээр олгоно. Ахлах ангийн сурагчдыг гамшгаас хамгаалах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын мэдлэг олгох сургалтад хамруулна.
- Сурагчдыг нийгмийн харилцаанд ороход нь бэлтгэж, сэтгэл судлал болон хүн хоорондын харилцааны соёлын талаарх хичээлийг боловсролын хөтөлбөрт тусгана.
- Үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхалтыг арилгах тогтолцоог бэхжүүлж, хүүхдэд аюулгүй цахим орчныг бүрдүүлнэ.
- Хүүхдийн зүй бус, албадан хөдөлмөр, мөлжлөгийг устгах, сургууль завсардалтыг үндсээр нь хална.

##### **Боловсролын тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлж, багшлах боловсон хүчнийг бэхжүүлнэ.**


- Алслагдсан бүс нутагт амьдарч байгаа хүүхэд, залуучуудын боловсролд онцгой анхаарч, зайны сургалтын орчин үеийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ,
- Хөдөө орон нутагт болон алслагдсан бүсэд багшлах багш нарыг дэмжих бодлого баримтална
- Багшийг дахин сургах, гадаадад сургах, туршлага солилцуулах “1000 багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



- Сургуулийн барилгын стандартыг шинэчилж, зураг төслийн зардлыг хэмнэх зорилгоор орон нутгийн онцлогт тохирсон ижил стандартуудтай болгоно.
- Сургуулийн эргэн тойрныг цэцэрлэгжүүлэх, биотоп байгуулах, цаг уурын ажиглалтын станц байгуулах замаар байгалийн ухааны хичээлийн туршилтын талбай болгон ашиглах боломжийг бүрдүүлнэ
- Боловсролын тэгш хүртээмжтэй байдлыг хангах, чанарыг дээшлүүлэх зорилгоор зайн сургалт, онлайн сургалтыг нэвтрүүлэхийг дэмжин ажиллана.
- Сургуулийн орчин өндөр хурдны интернэтэд бүрэн холбох, сургалтад ашиглах боломжийг бүрдүүлнэ.

**Эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулна**

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний төсөв санхүү, нөөцийг нэмэн өргөжүүлж иргэдэд хүртээмжтэй ойртох нөхцөлийг бий болгоно. Эрүүл мэндийн салбарын бодлого, төсөв, санхүүжилт, үйл ажиллагаанд ил тод, нээлттэй байдлыг бий болгож, авлига, ашиг сонирхлын тогтолцоог устгана. Эрүүл мэндийн салбарын төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үр ашгийг эрс сайжруулна.
- Эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, салбарын шинэ технологи нэвтрүүлэх сонирхлыг нэмэгдүүлэх хөшүүргийг оновчтой нэвтрүүлж, уламжлалт анагаах ухааныг орчин үеийн шинжлэх ухаантай зөв хослуулна.
- Эрүүл мэндийн бүртгэлийн салбарт мэдээллийн технологийг бүрэн нэвтрүүлэх. E-Клиникийн тогтолцоог бий болгож, өвчин, үзлэгийн түүхийг үйлчлүүлэгч өөрөө эзэмшиж, өөрийн хүссэн эмнэлэг, эмчийн сонгон үйлчлүүлэх нөхцөлийг хангана.
- Эмнэлгийн оношилгоонд хиймэл оюун ухаан, инноваци технологийг нэвтрүүлж, явуулын оношилгооны лаборатори болон эмнэлгийг орон нутагт бүрэн нэвтрүүлнэ.
- Сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж, эмчилгээний үйлчилгээг хөгжүүлж, олон нийтэд хүртээмжтэй, боловсронгуй болгоно.
- Архи, тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис, бусад төрлийн донтолт, хорт зуршлын хамааралтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх тогтолцоог сайжруулна. Архидалттай тэмцэх, архидалтыг сурталчилсан үүсмэл зан заншлыг халах, архидалтын эсрэг эмчилгээг хөгжүүлэхэд төрийн оролцоог нэмэгдүүлнэ
- Эрүүл мэндийн худалдан авалт, тоног төхөөрөмжийн импортын тогтолцоон дахь төр, хувийн хэвшлийн бүхий л харилцааг эрүүлжүүлнэ.
- Бүх шатны эмнэлгийн байгууллагын ажилтнууд, эмч, сувилагчдын нийгмийн байр суурь, үнэлэмж, хүндлэлийг нэмэгдүүлэх, эрүүлийг хамгаалах мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлнэ.
- Эмч, сувилагч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, давтан сургалт, гадаад болон дотоод туршлага солилцох хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Эрүүл мэндийн салбарт дотоод гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого баримтална.
- Эрүүл мэндийн санхүүжилтийн бүтцийг оновчтой болгох замаар, эрүүл мэндийн даатгалын бие даасан байдлыг бэхжүүлэн, иргэд эрүүл мэндийн үйлчилгээг оршин суугаа газрын харьяалал, өмчийн хэлбэр үл харгалзан эрүүл мэндийн даатгалаараа бүх шатлалын үйлчилгээг авах боломжийг бүрдүүлнэ.



- Эмзэг бүлгийн иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг өрхийн эмнэлэг, хорооны нийгмийн ажилтны ажил үүргийн хуваарьт суулгаж хэрэгжүүлэх, бүртгэлд бүрэн хамруулна.

**Төрийн албан хаагчийг дэмжиж, төрийн үйлчилгээг цахимжуулна. Авилгын эсрэг нийтийн хөдөлгөөнийг дэмжинэ.**

- Мэргэжлийн, чадвартай, ёс зүйтэй төрийн албан хаагчдыг төрд тогтвортой ажиллуулна. Ийм бололцоог хангахын тулд төрийн албаны зөвлөлийг хараат бус, бие даасан инстүүц байгууллага болгоно.
- Төрийн албан хаагчдыг бэлдэх, тасралтгүй давтан сургана.
- Төрийн ёс зүй, сахилга бат, хариуцлага, мэдлэг чадвар, чармайлт бүхий төрийн тогтвортой албан хаагчдыг төлөвшүүлэн хөгжүүлэх бодлого, зорилт тавьж хэрэгжүүлнэ.
- Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана.
- Төрийн үйлчилгээг цахимжуулж, ил тод нээлттэй болгож, хүнээс хамаарах хамаарлыг багасгаж, хүнд суртлыг бууруулах бодлого баримтална.
- Авлига төрийн албанд голдуу үүрлэсэн боловч хүүхэд, залуу үеэ авлигач сэтгэлгээ суухаас сэргийлэх, өөрийн мэдэлгүй буруу хэвшил сургаж буй дадал, соёлыг засах, ухуулга, сургалт таниулга хийх, олон нийтийн хөдөлгөөн болгох, нийгмийн бүх гишүүдийн оролцоо, дэмжлэгийг авна.
- Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд хуулийн салбарт үүссэн “хамжлагат” ёсыг халж, хараат бус, хуульд, төрд үнэнчээр зүтгэх, ёс зүйт, хүний эрхийн төлөө хандлагатай албан хаагчдаар бүрдүүлэх, тэдний эрхийг хангах нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгааг хангах бодлогыг дэмжиж хэрэгжүүлнэ.
- Уул уурхайн хөрөнгө оруулагчид орон нутагтай хамтран ажиллах нэрийдлээр орон нутгийн засаг захиргаа, иргэдэд шууд болон шууд бус татаас, хандив өгч авлигажсан сэтгэлгээ, орчин бүрдүүлдгийг цэгцэлж, илт тод, иргэдэд болон нийтэд өгөөжтэй болгон журамлана.

**Шударга, цэвэр, ёс зүйтэй Монгол нийгмийг бүрдүүлнэ.**

- Шударга ёсыг бэхжүүлэх, авлигыг устгах чиглэлээр боловсрол, нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээг хамарсан цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Ёс зүйтэй Монгол хүн, Монгол нийгмийг төлөвшүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ. Нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх орчин бүрдүүлнэ.
- Хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн ялгааг бууруулах, хөдөлмөрийн зах зээл дээр шинэ боломжийг нээж өгнө.
- Эмэгтэйчүүдийн далд дарангуйллыг устгах, хүн худалдаалах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэнэ.

- Ёс суртахууны доройтол, архидалт, мансуурал, садар самуун зэрэг нийгмийн гаж үзэгдэлтэй хуулийн хүрээнд тууштай тэмцэж нийгмийг эрүүлжүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгааг нь хангана.
- Байгаль орчны болон хүнс, эм, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний аюулгүй байдалд тавих төрийн хяналтыг эрс чангатгана.



195

## V. БАЯЛГАА ЗӨВ УДИРДАХ

*Эдийн засгийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулна*

Эдийн засаг, бизнест тэгш боломж, шударга өрсөлдөөнийг бий болгох зарчмыг мөрдлөг болгон, хөдөлмөрлөсөн нь сайхан амьдардаг, хичээсэн нь амжилт гаргадаг, боломж чадвараар дутуугаа гээдэггүй, хүний наад захын эрэлт хэрэгцээ хангагдсан, шударга нийгмийг цогцлон байгуулна.

- Иргэн бүрд жигд боломж, нөхцөлийг олгосон баялгийн шударга хуваарилалтыг хэрэгжүүлж, авилгаас ангид бие даасан, хэсэг бүлэг этгээдийн шунал, хүсэлд захирагдаагүй сахилга баттай шударга чөлөөт зах зээлийн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлж төсвийн хөрөнгө оруулалтын шинэчлэл хийх бодлого баримтална. Салбарын болон орон нутгийн хэрэгцээ шаардлагыг бодитоор тооцоолж, улсын нийгэм эдийн засгийн хөгжилд түлхэц болох төслүүдийг эрэмбэлэн санхүүжүүлж, хөрөнгө оруулалтын шийдвэр болон санхүүжилтийг ил тод болгоно.
- Төрийн санхүүжилттэй нийтийн чанартай төсөл, засгийн газрын ханган нийлүүлэлтийн төслийн бараа үйлчилгээний тендер, худалдан авалтыг шударга явуулахад онцгой анхаарч, хэрэгжилтийг ил тод, нийтийн хяналт дор явуулна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, бүрэн хөдөлмөр эрхлэлттэй улс болохын төлөөх бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ.
- Эдийн засаг, бизнест хэт дарамт учруулахгүй, энгийн ойлгомжтой, үр нөлөө бүхий, шударга татварын тогтолцоог бий болгоно. Бизнесийн шударга орчин, шударга өрсөлдөөнийг бий болгоно.
- Нийгмийн баялгийг зохистой, шударга хуваарилах, эдийн засгийн хөгжлийг тэтгэх татварын оновчтой бодлогыг хэрэгжүүлж, албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан салбарт хамруулна.
- Хүн амын орлогын өсөн нэмэгдэх шатлалтай татварын зарчмыг нэвтрүүлнэ. ХХОАТ-г тэжээгдэгч гэр бүлийн гишүүдийн тооноос шалтгаалсан хөнгөлөлт үзүүлэх бодлогыг дэмжиж хэрэгжүүлнэ.
- Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжиж, бага хүүтэй урт хугацааны зээл авах боломжоор хангах, ажлын байр нэмэгдүүлэх хөшүүрэг болгох арга хэмжээ авна.
- Дэлхийн шилдэг туршлагад (тухайлбал, Грамин банк) тулгуурласан “Бичил зээл”-ийн тогтолцоог бүрдүүлэхэд бодлогын болон хууль эрх зүйн дэмжлэг үзүүлнэ.
- Ядуурлаас гарахад зориулсан мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг байгуулж, сургалтыг төрийн зүгээс тогтмол явуулдаг болно. Иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан тогтвортой ажил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд орох боломжийг бүрдүүлэх, цаашлаад ажил хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлэх.
- Нийгмийн халамжийн хүртээмж, оновчтой байдлыг сайжруулах, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн амьжиргааны баталгааг хангахыг зорино.

Огос

- Бага насны хүүхэд ядууралд өртөх, хүнс тэжээлийн дутагдалд орох, орон гэргүйн улмаас амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал нь эрсдэх нөхцөл байдлыг арилгахыг зорино.

**Мал аж ахуйн эдийн засгийн үр ашгийг сайжруулж, малчдын бодит орлогыг нэмэгдүүлнэ.**

- Хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуйг тэргүүн ач холбогдол бүхий салбарын түвшинд авч үзэж хөгжүүлэх бодлого баримтална.
- Малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ.
- Мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах салбарыг төрөөс тууштай дэмжих бодлого баримталж, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний нэмүү өртгийн гинжин хэлхээг бүрэн болгож, төгөлдөршүүлнэ.
- Хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан хот суурин газруудын ойролцоо эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлэх бодлого баримтална.
- Арьс шир, мах, сүү, ноос зэрэг малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах санаа санаачлагыг дэмжиж, малчдын бодит орлогыг нэмэгдүүлнэ.
- Мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталгаажуулсан худалдаа, хорио цээрийн шаардлагад нийцсэн мал, амьтны өвчингүй статустай нутгийн хэмжээг нэмэгдүүлж, мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг хөрш орнуудын зах зээлд гаргах мал эмнэлгийн эрүүл ахуйн зохистой орчин бүрдүүлж, үндэсний мал, амьтны эмнэлгийн тогтолцоог боловсронгуй болгох.
- Төмөр замын үйлчилгээнд НАССЕР-т нийцсэн мал нядалгаа, оношилгоо, эрүүлжүүлэлтийн явуулын лаборатори вагон нэвтрүүлж, малын мах, бүтээгдэхүүнийг Орос, Хятадад экспортлох боломжийг бүрдүүлэх
- Мал аж ахуй, хөдөө аж ахуйн эрүүл бүсийг бий болгож, баталгаажуулна. Мал, амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэн, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүнийг экспортлоход тэргүүн ач холбогдол өгнө.
- Сум болгонд малын эрүүл ахуйг хангах, түүхий эд цуглуулах төвүүдийг өмчийн олон хэлбэртэйгээр байгуулж хөдөө аж ахуйн биржтэй хослон ажиллуулах бодлого баримтална.


**Бизнес эрхлэлт, үйлдвэрлэлийн хөгжлийг бодлогоор дэмжинэ.**



- Бизнесийн салбарт бизнес эрхлэх шударга, тогтвортой орчин бүрдүүлж, компанийн засаглал, бизнесийн ёс зүйг сайжруулж, зөвлөх үйлчилгээг дэмжинэ.
- Мэдлэг, инновацийг дээдэлсэн эдийн засгийн ач холбогдолтой бизнесийн төслүүдийг дэмжинэ.
- Дотоодын нөөц бололцоогоор хийх боломжтой ажлын байрыг хамгаалж, өөрийн орны иргэдийг ажиллуулах, эрэлт хэрэгцээ өндөртэй болон ирээдүйд шинээр бий болох ажлын байруудад боловсон хүчнийг сургах, бэлтгэх бодлого баримтална.
- Хүйтнийг даван туулах технологийг бүхий л талаар дэмжин, дулаан алдагдал багатай барилгын материал үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого баримтална.
- Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого баримтална.
- Олон улсын туршлага, өөрийн орны боломж, нөхцөлд нийцүүлэн эдийн засгийн, экспортын, худалдааны чөлөөт бүсүүдийг хөгжүүлж, үйлдвэрлэлийг төрөлжүүлэх бодлого баримтална. Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлнэ.
- Үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоод эх үүсвэрээр бүрэн хангаж, хот, суурин газрын бүсэд хөдөө аж ахуйн кластерыг хөгжүүлж, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа махны 30 хувь, сүүний 40 хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулна.
- Хүнсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Худалдаа, үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, чанарыг сайжруулах, хилийн боомт дахь байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, хялбаршуулж гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг дорвитой бууруулж, худалдааны өртөг, зардлыг хямдруулна.
- Өргөн уудам нутагтай, хүн ам цөөнтэй, жижиг зах зээлтэй улсын хувьд цахим худалдаа, үйлчилгээг хөгжүүлж, газарзүйн алслагдмал байдалтай холбоотой бизнесийн өртөг, зардлыг хямдруулна.
- Уул уурхайн олборлох салбарт тулгуурлан аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, нүүрс-хими, нефть-хими, эрчим хүч, дэд бүтцийн салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгнө.

**Аялал жуулчлал**

- Манай улсын харьцангуй давуу тал болох аялал, жуулчлалын үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, экспортын орлогын тогтвортой эх үүсвэр болгох бодлого баримтална.
- Аялал жуулчлалын үйлчилгээний олон улсын стандартыг нэвтрүүлж, дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулна. Аялал жуулчлалын олон төрөл, улирлын онцлогтой аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого баримтална.
- Жуулчдын статистик бүртгэл хөтлөх, судалгаа хийх тогтолцоог бэхжүүлж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх бодлого баримтална.





- Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал, нүүдлийн соёл иргэншлийг танилцуулах жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх бодлого баримтална.
- Орчин үетэй зохицон хөгжиж буй нүүдлийн соёл, ахуйтай танилцах болон байгаль орчинд ойр, эрүүл амьдралын хэв маягийг мэдрүүлсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүнийг хөгжүүлэх.
- Музей, соёл урлаг, түүх, уламжлалт зан заншилыг хамарсан зөөлөн хүчний бодлогыг аялал жуулчлалтай уялдуулна.

----- о 0 о -----

